

# “ЭРДЭНЭС СИЛВЕР РЕСУРС” ХХК-ИЙН САЛХИТЫН УУРХАЙН ХААЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ ЖИШИГ ТӨСЛИЙН МЭДЭЭ

Дугаар 1 2021 оны 10-р сар

## ■ ТАНИЛЦУУЛГА

Канад Улсын Засгийн газрын санхүүжилттэй “Монгол Улс: Институцийн өөрчлөлт хийх замаар эрдэс баялгийн менежментийг сайжруулах нь” MERIT төслийн дэмжлэгтэйгээр “Эрдэнэс Монгол” группын харьяа “Эрдэнэс Силвер Ресурс” ХХК хариуцан хэрэгжүүлэх Салхитын мөнгөний ордын Хаалтын менежментийн төлөвлөгөөг загвар байдлаар боловсруулах (цаашид “Жишиг төсөл” гэх) төслийг төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагын дэмжлэг, хамтын ажиллагаанд тулгуурлан хэрэгжүүлнэ.

Цаашид бусад уурхайд жишиг болохуйц хаалтын менежментийг төлөвлөх сайн туршлагыг бий болгох зорилготой уг жишиг төслийн зөвлөх үйлчилгээг үндэсний тэргүүлэх туршлага бүхий “Кью Эм Си” компани болон олон улсад байгаль орчны зөвлөх үйлчилгээ үзүүлдэг Канад улсын “Си Пи Пи Энвайронментал” корпорацийн баг хамтран хүргэх юм.

## ■ ҮНДЭСЛЭЛ



Салхитын холимог металлын орд Улаанбаатар хотоос өмнө 280 км-ын зайд, Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутагт оршдог (<http://erdenessilver.mn/62/single>).

“Эрдэнэс Силвер Ресурс” төрийн өмчит компани нь уурхайн хаалт болон нөхөн сэргээлттэй холбоотой хууль, журмаа сайтар мөрдөх, сайн туршлагаар түүчээлэхийг зорьж байна. Салхитын мөнгөний ордын ашиглалт цаашид ойролцоогоор 8 жилийн хугацаанд үргэлжлэх боловч Монгол улсын холбогдох хууль, журамд заасны дагуу хаалтын төсөөллийг эрт төлөвлөн батлуулах шаардлагатай юм.

## ■ ХААЛТЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨЛТИЙН ТУХАЙ

Компанийн түвшинд уурхайн хаалтыг төлөвлөх үйл явц нь барилга, байгууламжийг буулгах, нөхөн сэргээх, орчны хяналт шинжилгээ хийх зэрэг цогц үйл ажиллагааг шинжлэх ухааны үндэслэлтэй, хөрөнгө зардал хэмнэсэн байдлаар оновчтой шийдвэрлэж, хаалтын дараах тогтвортой газар ашиглалт, аюулгүй амьдрах орчныг бүрдүүлэх эцсийн үр өгөөжийг сайжруулахад чиглэнэ. Монгол улсад төсөл хэрэгжүүлэгч аж ахуй нэгжүүд уурхайн амьдралын мөчлөгийн бүх үе шатанд хаалтын менежмент, төлөвлөлтийг оновчтой хэрэгжүүлж, компанийн бизнесийн болон санхүүгийн төлөвлөлтөд тусгасан байхыг холбогдох хууль, тогтоомжид тодорхой тусгаж эхлээд байна.

## ■ ЖИШИГ ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Жишиг төсөл нь **4 үндсэн** зорилготой. Үүнд:

- 1▶ Уурхайн хаалттай холбоотой Монгол улсын холбогдох хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх техникийн чадавхыг бэхжүүлэх;
- 2▶ Хаалтын менежментийн төлөвлөгөө боловсруулах үйл явцад оролцогч талууд болон сонирхолын бүлгүүдтэй мэдээлэл солилцох, зөвлөлдөх, тэдний саналыг тусгах зэрэг бүтээлч, оролцоонд тулгуурласан арга хэлбэрийг хэрэгжүүлэх;
- 3▶ Салхитын мөнгөний ордын Хаалтын менежментийн төлөвлөгөөг шинжлэх ухааны үндэслэлтэй, техникийн оновчтой шийдэл бүхий олон улсын сайн туршлага болон Монгол улсын хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулах;
- 4▶ Монгол улсын уурхайн хаалтын менежментийн бодлого, зохицуулалт, хэрэгжилтийг сайжруулах, давхардал, хийдлийг арилгах зөвлөмжөөр хангах.

## ■ ТӨСЛИЙН ҮЕ ШАТ

Төслийн хэрэгжилт нь хоёр үндсэн үе шатаас бүрдэх бөгөөд үе шат тус бүр нь тодорхой хүлээгдэх үр дүнтэй. Хоёрдугаар үе шат хэрэгжсэний үр дүнд Салхитын мөнгөний ордын хаалтын менежментийг төлөвлөгөөг эцэслэж, батлуулахаар эрх бүхий төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

### Үе шат 1

1. Монгол улсын эрх зүйн орчны шинжилгээ хийх болон олон улсын сайн туршлагыг судлах;
2. “Эрдэнэс Силвер Ресурс” ХХК-аас мэдээлэл цуглуулах, Салхитын мөнгөний ордын өнөөгийн байдлын суурь судалгаа хийх;
3. Байгаль орчны төлөв байдлын судалгаа, орчны хяналт шинжилгээ хийх
4. Хаалтын төлөвлөлтийн зорилго, зорилтуудыг тодорхойлоход талуудын оролцоог хангах;
5. Суурь судалгааны дүн болон өмнөх туршлагыг үнэлж Эрсдэлийн дүн шинжилгээ хийх.

Төслийн хоёрдугаар үе шатыг амжилттай хэрэгжүүлэхэд төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагууд, аж ахуйн нэгж, техникийн зөвлөхүүд, бусад оролцогч талуудын нягт хамтын ажиллагаа ихээхэн чухал юм.

### Үе шат 2

1. Нэгдүгээр үе шатны үр дүнг үндэслэн, хэрэв шаардлагатай бол орчны төлөв байдлын судалгаа, дээж авах, лабораторын шинжилгээ хийх зэрэг ажлуудыг нэмэлтээр гүйцэтгэх;
2. Хаалтын менежментийн жишиг төлөвлөгөөг боловсруулах;
3. Хаалтын менежментийн төлөвлөгөөний төслийг холбогдох талуудад танилцуулж санал авах, зөвлөлдөх;
4. Салхитын мөнгөний ордын хаалтын менежментийн төлөвлөгөөг эцэслэж, “Эрдэнэс Силвер Ресурс” ХХК –ын зүгээс эрх бүхий төрийн захиргааны төв байгууллагад батлуулахаар хүргүүлэх.

## ■ АРГА ХЭМЖЭЭ



Зүүн гар талаас: Дундговь аймгийн Засаг дарга **Ц.Мөнхбат**, Эрдэнэс Силвер Ресурс ХХК-ийн Гүйцэтгэх захирал **С.Баярмөнх**; MERIT төслийн Захирал **Женнифер Адамс**; УУХҮЯ-ын Уул уурхайн бодлогын газрын Техник технологийн хэлтсийн Дарга **Ч.Цогтбаатар**

Салхитын мөнгөний ордын уурхайн хаалтын төлөвлөгөө боловсруулах жишиг төслийн нээлт 2021 оны 9-р сарын 24-ний өдөр болов. Тус арга хэмжээнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам (УУХҮЯ), Дундговь аймаг, “Эрдэнэс Силвер Ресурс” ХХК, Байгаль орчин, аялал жуулчлалын яам (БОАЖЯ), Ашигт малтмал газрын тосны газар (АМГТГ) зэрэг холбогдох төрийн болон нутгийн захиргааны байгууллагуудын удирдлагууд оролцлоо. Энэ үеэр MERIT төслийн зүгээс жишиг төслийн хэрэгжилт болон эхний үе шатанд хийгдэх ажлууд, хүлээгдэж буй үр дүнг танилцуулж, оролцогч тал тус бүрийн үүрэг, оролцооны талаар хурлын төлөөлөгчид зөвлөлдөж, санал нэгдсэн. Энэхүү уулзалт нь жишиг төслийн зорилго зорилт, хэрэгжүүлэх арга замын талаар талууд санал солилцож, нэгдсэн ойлголтод хүрсэн өндөр ач холбогдолтой арга хэмжээ болов.

### ХОЛБОО БАРИХ

Жишиг төслийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл  
Төслийн дэд захирал **Р.Алтангэрэл**

✉ [r.altangerel@merit.mn](mailto:r.altangerel@merit.mn) хаягаар холбогдоно уу.